

“ГЭСЭРИЙН ТУУЖ” ДАХЬ ХАТДЫН ДҮРИЙН ОНЦЛОГ

С.Дашдэжид

**Түлхүүр үгс:** *Тууж, хатад дагинас, бэлгэдэлт дүр, уран дүрслэл*

“Гэсэрийн тууж”-д үзэсгэлэнт хатад, хүлэг сайн морьд, газар нутаг, эдлэн эзэмшлийн төлөө тэмцэлдэн эрэлхэг зориг, авьяас чадвараараа өрсөлдөх баатруудыг гадаад төрх, эдэлж хэрэглэдэг зүйлс, эрдэм ухааныг нарийн тоочин өгүүлэхдээ уран дүрслэлийн аргыг чадамгай ашигласан байдал нь зохиолыг яруу тансаг, хайлсан хүн ханашгүй, сонссон хүн марташгүй чихнээ хоногшин үлддэг байжээ.

Хүний оюун санааны ертөнц, бодот байдал, хүсэл мөрөөдөл, амьдрал тэмцлийн далд чанадыг үлгэр туульс, зохиол бүтээлд уран сэтгэмжээр нөхцөлдүүлэн, уран дүрээр амьдруулан, уран дүрслэлээр чимэглэн илэрхийлэх туршлага олон зууныг дамнан аман болон бичгийн уран зохиолоор уламжлагдан иржээ. Үүний тод жишээ болох “Гэсэрийн тууж”-ийн олон хувилбаруудыг харьцуулсан судлаж, агуулга, бүтэц, хэв шинж, дүр, дүрслэлийн онцлог зэргийг нарийн ажиглах, харьцуулалт хийх, тайлан тайлбарлах шаардлагатай байна. Энэхүү өгүүллийн хүрээнд “Бээжин барын Гэсэрийн уран сайхны онцлог”-ийг ажиглахдаа хатдын дүр онцлон үзлээ.

“Гэсэрийн тууж”-д монгол үлгэр домогт цөөнгүй ажиглагддаг бэлгэдлийн метафор-адилтгал дүр олон байна. Тухайлбал, “Алтан хэнхдэгтэй, мөнгөн бөгстэй” хэмээн Журын хувилгааны дүрийг дүрсэлсэн хэллэгт “алтан хэнхдэгтэй” гэдэг нь “ухаантайг” хэлж буй. Бид алтан цээжтэй ч гэлцдэг. Энэ хэллэг Жангар тууль зэрэгт “ирсэн 99 жилийн юмыг тоочин хэлдэг, ирээгүй 99 жилийн юмыг тааж мэддэг” Алтан Цээж бааваа гэдэг баруун биеийг ахалсан ер бишийн ухаантай баатрын дүр гардаг. Тэгээд ч монголчууд ухаантай, эрдэмтэй хүнийг “цээжтэй хүн” гэдэг нь их юм мэддэг сав сайтай, ой тогтоолж онцгой гаргууд гэсэн утгатай. Харин “мөнгөн бөгстэй” гэдэг нь цалин мөнгө мэт цэвэр ариун бие цогцтой, цэвэр ариун үйлс явдалтай хүн гэсэн санаа юм. Энэхүү адилтгасан бэлгэдэлт дүрслэл Гэсэрийн хатдын дүрд тод ажиглагддаг. Тухайлбал, Жало хааны охин, есөн зүйл төгссөн дагинасын хувилгаан Рогмо гуа, Ма баяны охин, хөрст алтан дэлхийн хувилгаан төгссөн Арлан гуа (Түмэнжаргалан), Лусын хааны охин, мэргэн харваач Ажу мэргэн, Чойрон урны охин хөхөө шувууны хувилгаан төгссөн Чоймсон гуа хатан, Хятадын Гонма хааны охин, амьтны хувилгаан төгссөн Гүнэ гуа хатан гэсэн таван хатны эхээс мэндэлсэн шинж төлгө, эрдэм чадал, рид хувилгаан, гоо үзэсгэлэнт уран нарийн тоочин өгүүлжээ.

Эрдэмтэн Г.Ринченсамбуу: “монгол туульд дахь авхай дагинас, хатдын дүрийг: 1.Бие бялдарын гоо сайхан, 2. Сэтгэл журмын гоо сайхан, 3. Зориг баатарлагийн гоо сайхан, 4. Авьяас билгийн гоо сайхан, 5.Ажил үйлсийн гоо сайхан, 6. Бадрангуй тэмүүлэлийн гоо сайхан гэсэн хэдэн шинж төлөвөөр тусган илэрхийлдэг” (Ринченсамбуу, 1998:375) гэжээ. Гэсэрийн

туужид хатдын гоо сайхныг өгүүлэхдээ хоёроос гурван шинжийг онцгойлон дурдсан байдлаас ажиглавал монголчуудын гоо сайхны сэтгэлгээ болон эмэгтэй хүний ямар зан чанарыг чухалчлан үздэг байсныг харж болох юм. Тухайлбал,

**Рогмо гуа хатны гоо үзэсгэлэн, цаглашгүй сайхны тухай** өгүүлэхдээ, ...*Намайг төрөхөд баруун дээвэр дээр сэру (хирс) гөрөөс тоглож байсан билээ. Зүүн дээвэр дээр минь Оролог нэрт гөрөөс тоглож байсан билээ. Наргүй өдөр гэрэл гарч байсан билээ. Үүлгүй өдөр бороо орж байсан билээ. Ноёны тулган дээр минь тоть шувуу донгodoж байсан билээ. Хатны тулган дээр минь хөхөө шувуу донгodoж байсан билээ. Боолын тулган дээр минь Урангадайн гуа шувуу донгodoж байсан билээ”* (Гэсэрийн, 31) хэмээн түүнийг хорвоод мэндлэх үеийн дохио тэмдэг, есөн зүйл төгссөн дагинасын хувилгаан хэмээсэн нь олон талын эрдэм авьяастай болохыг хэлжээ. Түүний гадаад гоо сайхныг “*босоо бие нь ургамал нарс модыг ханхуй нэрт магнаг торгоор бүрсэн мэт, Суугаа бие нь таван зуун хүн суух орд цагаан гэр мэт. Баруун мөрөн дээр нь алтан шумуул эргэж байна. Зүүн мөрөн дээр нь мөнгөн шумуул эргэж байна. Баруунтаа наранд суувал хайлах мэт. Зүүнтээ сарны сүүдэрт суувал царцах мэт. Шөнийн гэрэлд нь зуун мянган алт манах мэт. Ийм цаглашгүй сайхан байна”* (Гэсэрийн, 98) хэмээн Рогмо гуа хатны гоо үзэсгэлэнг гэрэл гэгээтэй холбон гэрт байхаараа гэрийг гийгүүлсэн, гадна гарахлаараа орчлонг гийгүүлсэн өнгө үзэсгэлэнт нарт ертөнцөд түүнтэй энэ зэрэгцэх нэгэн үгүй хэмээн бие бялдарын гоо сайхныг өгүүлжээ.

Монгол аман болон бичгийн уран зохиолд бүсгүй хүний гоо үзэсгэлэнг гэрэл гэгээтэй холбон тайлбарлах уламжлал арвин бий. Тухайлбал,

Эмийн нь хоолойгоор наран гарч

Хуулзараар саран гарч байнам (Чингис хааны, 7)

хэмээн Өүлэнийг шинжиж буй сонирхолтой өгүүлэмжид хоолойгоор нь наран гарч, хуулзараар нь саран гарч буйгаар дүрсэлсэн нь монгол ардын баатарлаг туульд эмэгтэй хүний гоо сайхныг гэгээн цагаан гэрлээр төлөөлүүлэх ба наран саран эрхэсээр бэлгэдсэн дүрслэлтэй холбоотой.

*Баатарлаг туульст авхай дагинасын гоо үзэсгэлэнг дүрслэхдээ:*

Цуснаас улаан хацартай

Цаснаас цагаан царайтай

Гэр нэвт гэрэлтэй

Гэгээн цагаан царайтай

/Гишүүн улаан хацартай/

Туурга нэвт туяатай

/Тунамал ягаан хацартай/

*гэхчлэн нигуурын өнгө үзэсгэлэнг чухалчилж, ямагт гэрлийн үүтгэлт гэгээн цагаан өнгөөр бэлгэдэх ба хатдын хацар халхыг “цуснаас улаан”, “гишүүний улаан”, “тунамал улаан” гэхчлэн гэрлийн улаан ягаан өнгөөр бэлгэдэн дүрсэлдэг байна. Энэ нь эрүүл чийрэг бие бялдарын гоо сайхныг бэлгэдэхийн зэрэгцээ эрхэм дээд өөдрөг бадрангуй, баяр хөөр, цог жавхланг илтгэж байна* (Нандинбилиг, 2004:37). Ийнхүү бүсгүй хүмүүний гоо сайхныг наран сарантай холбох болсоныг ертөнцийн үүслийн домгуудаас эрэлхийлж болох юм.

*“Нар сар хоёр уг нь нэгэн их баян айлын гоо үзэсгэлэнт охид байсан юмсанжээ. Тэгээд эгч, дүү хоёр газарт ханилах, тэнцэх эр нөхөр олдохгүй болохоор нар, сар болж тэнгэрт гарч хүн амьтныг гэрэлтүүлж, гийгүүлж явах болсон гэнэ. Уг нь эгч нь сар больё гэсэнд дүү нь өдөр явахад олон хүн харна гэж ичиж зовоод эгчийгээ өдөр яв гэж өөрөө сар болоод шөнө явах болсон юм санжээ”* (МАДУ, 2010:55-56) үлгэрт эгч дүү хоёр өөрсдийн гоо үзэсгэлэн

өнгө гэрлийн сайхнаар хүн амьтныг гэрэлтүүлж, гийгүүлж явах болсон хийгээд энэхүү өгүүлэмж монгол баатарлаг туульс, бичгийн уран зохиол болон хожмын хатад, бэргэн сонгох шинжээ сударт уламжлагдан авхай дагинас, хатдын гоо үзэсгэлэнгийн өнгө төрх болон дотоод сэтгэлийн гоо сайхныг гэрэл гэгээ наран, сарантай зүйрлэн бэлгэдэн зүйрлэсээр иржээ.

Хэдийгээр Рогмо гуа өнгө гэрэлтэй сайхны туйл боловч явдал үйл, зан чанарын тухайд эсрэгээрээ дүрслэгдсэн байдаг. Туужид буй хэд хэдэн өгүүлэмжээс түүний дүрийг тодруулбал,

- Арлан гуа хатанд хар буруу санан мангасын газарт хөөсөн,
- Шарай голын Цагаан гэрт хааны хатан болсон,
- Цагаан гэрт хаанд урваж Гэсэрийн эсрэг хуйвалдсан,
- Цагаан гэрт хаан хүүг төрүүлсэн,
- Ловсгаа мангасын эхнэр болсон зэргээр өнгө үзэсгэлэн нь хорвоод хосгүй, цаглашгүй сайхан хэдий ч шарыг үзэн шарваж, улааныг үзэн урвах туйлбаргүй шинжийг харуулжээ. Хэдийгээр есөн зүйлийн хувилгаан увидастай боловч эрдэм чадлын хувьд гайхагдах юмгүй харин есөн зүйлийн элдэв янзын олон ааш аяг, авир төрхтэй гаднаа гяланцаг, дотроо паланцаг эмэгтэйн дүр юм. Туужийн төгсгөлд Рогмо гуа Гэсэрээс удаа дараа урван, түүний эсрэг мангас, дайсантай хуйвалдсан явдлыг уучлан өршөөсөн ч хамаарах эд мал, харьяат албатыг нь хураан ганц гэрээр буулгадаг. Рогмогийн дүрээр түүний туйлбаргүй зан төрхийг жигшин бусдад үлгэр жишээ болгон сургамжилжээ. Ерөөс монголчууд бид эртнээс охид бүсгүйчүүдийг эрдэм номтой, ажил үйлсэд гавшгай, үйлэнд уран, үгэнд цэцэн, элбэрэл тахимдуу, үнэн зөв явдалтай байхыг бага балчираас нь захин сургаж үлгэр домог, баатарлаг туульсаараа ухааруулан ойлгуулдаг байжээ.

**Лусын хааны охин Ажу мэргэний эрдэм чадлыг** өгүүлэхдээ, “Гэсэр хаан Ажу мэргэн хоёр хамт явахад Гэсэр хааныг долоон бух дайрч ирэв. Долоон бухыг шувт харваад, газар хадтал харвав би. Түүний хойно Ажу мэргэнийг есөн бух дайрч ирэв. Ажу мэргэн есөн бухийг шувт харваад хадыг хадтал харвав... Эр хүн гурван удаа барилдах биш үү. Дөрвөн үе тоосоо гөвөлцөх биш үү” (Гэсэрийн, 47-48) хэмээн барилдаж эр хүнээс илүүрхсэн хурц мэргэн, бяр тэнхээтэй гоо үзэсгэлэн төгс нэгэн билээ.

Туульст хатад дагинасыг эрдэм чадлыг үзүүлэхдээ “арван таван наст арал Гуа хатан нь далан хоёр чавхдаст нарийн хар ятгыг үе гишүүгээ сулартал цохин суусан”, Хан Харанхуй туулийн Үүлэн Солонго дагина “Зүрийн ясаар зүүж, зааны ясаар заадаслаж хийсэн, нарийн хар ятгыг Үүлэн Солонго нь нэгэн үе эгшиглэн цохиход үзэж суусан улсын үе гишүү нь суларч, хоёр цохиход үүлэн цагаан өргөөний магнаг торгон хөшиг дэрвээж дэрвээж байсан” (Баясгалан, 2010:120-121) хэмээн цуур, хуур, ятга зэрэг хөгжмийг сайхан аялгуулан цохидог гэж дүрсэлснээс биш Ажу мэргэн шиг эр хүнтэй, нум сум, бөх барилдаанаар өрсөлдөн авьяас чадвараар илүүрхэж буй өгүүлэмж цөөн юм.

Туужид Ажу мэргэний дүрийг тодруулж буй өгүүлэмжүүд гэвэл,

- Рогмо гуаг авахаар ирсэн Цагаан гэрт хааны Алтангэрэлт тайжтай тулалдан хөнөөсөн,
- Алтан дагина (Рогмо гуа) Арлан гуа хоёрын маргааныг ухаант үгээр эвлэрүүлэн Цасын хүү Лайцавыг Рогмод өгүүлдэг,

- Гэсэрийг мангасын оронд илжиг болоод зовж байхад Ажу мэргэн очиж авардаг,
- Гэсэрээс урвасан Алтан дагины буруу боловч өршөөж, энэрэхийг гуйхад “Гэсэр, Ажу мэргэний үгээс үл давахын тул Алтан дагины аливаа бүгдийг Ажу мэргэн төгсгөж өгөв” гэх зэргээр эрэлхэг дайчин төдийгүй бусад хатад болон Гэсэр хаан түүний үгийг хүндэтгэн дагадаг

ухаант хатан юм. Садарсан үсээ шууж, саадаг нум агсан эх орон элгэн садан, эрх чөлөөнийхөө төлөө эрэмгий зоригтой, дайчин баатарлаг их хатдын байгуулсан гавьяа түүхийн нэгэн жишээ Ажу мэргэн хатны дүрээр гоо үзэсгэлэнтэй, сайхан царайтай байхаас илүүтэй эрдэм чадалтай, ухаан билигтэй, бусдад тустай явахыг чухалчлан сургамжилсан байна. Туужийн төгсгөлд Ажу мэргэний үгээр аливаа асуудлыг шийдэж байгаа нь ухаант хатдын мэргэн зөвөлгөөг төрийн хэрэгт сонсон хэрэглэдэг уламжлалыг тусгажээ.

**Ма баяны охин, хөрст алтан дэлхийн хувилгаан төгссөн Арлан гуаг (Түмэнжаргалан)** дүрслэхдээ, “цааш харвал түмэн хүн инээх мэт, нааш харвал түмэн хүн инээх мэт өнгө дүртэй” (Гэсэрийн, 65) гэсэн нь хатан урдуураа гарсан бүхнийг ундаалж, хойгуураа гарсан бүхнийг хооллон дээр доор, сайн муу, сайхан муухай, хөгшин залуу, баян ядуу гэлтгүй олон түмэнтэйгээ байж жаргал зовлонгоо хуваалцаж элбэрэл тахимдуу, элгэсэг дотно сэтгэлээр ханддаг үлгэр жишээ бэр юм.

Эмэгтэй хүн төр эр, нэр эр, авсан эр гурвыг чухалчлан хичээж байхыг хадамд очиж буй охиндоо хичээнгүйлэн захидаг уламжлалтай. Төр эр бол хууль цааз, ёс журам, заншил элдэв цээр ёс юм. Үүнийг дээдлэн сахиж хатан хүмүүний арван таван шинжийг бүрдүүлж хатуужваас нэр эр ирнэ. Айл саахалт, улс иргэндээ нэр хүндтэй, үлгэр жишээ бүсгүй хүнээс авсан эр хаа холдох билээ. Ийнхүү эмэгтэй хүн бүрийн даган сахих ёсыг гурвын тоонд хураангуйлан өсч олширч байхын чанад бэлгэдлээр товч үгээр гүн утгыг гаргажээ. Ийнхүү туульд Арлан гуа хатныг дүрслэхдээ хатад дагинасын ёс журмыг сахигч, цааш харвал түмэн хүн инээх мэт, нааш харвал түмэн хүн инээх мэт өнгө дүртэй, үйлдэл явдалтай нэгэн хэмээн дүрсэлжээ. Туужид буй өгүүлэмжээс түүний дүрийг тодруулбал,

- Рогмо гуа, Цотон хоёр хуйвалдан Арлан гуаг хөөхөд Гэсэр эзний минь чилээ сайн болтугай хэмээн өөрийн жаргалыг үл тоон явдаг,

- Хамаг улс хорооныхоо үгээгүү ядууг цуглуулан өглөг хишгээ хүртээн энэрч, хайрладаг учраас жаргах газар бүгдээр жаргая, зовох газар бүгдээр зовьё бид хэмээн Арлан гуаг дагаж уйлдаг,

- Гэсэр арван хоёр толгойт мангастай тулалдан Арлан гуа хатны тусламжтайгаар аливаа төрөлтэй нь таслан устгадаг,

- Гэсэрт аливааг мартуулах баг нэрт идээг өгсөөр өөрийн дэргэд есөн жил суулгав.

Туужид Арлан гуа хатан ёс журмыг эрхэмлэдэг хэдий ч Гэсэр хааныг өөрийн дэргэд удаан хугацаагаар байлгах хүслээсээ болж жөтөөрхөгч хатны араншин гаргадаг.

### Дүгнэлт

1. “Гэсэрийн тууж”-ид авхай дагинас, хатдын гоо үзэсгэлэн, эрдэм чадал, оюун ухаан төгөлдөр, ааш аягийн сайхныг наран, саран мэт гэрэл гэгээтэй, рид хувилгаан увидастай, эрэлхэг баатар шинжтэйг бэлгэдлийн метафор-адилтгалын аргаар дүрсэлсэн байна.
2. Рогмо гуа хатан цаглашгүй гоо үзэсгэлэн, Ажу мэргэн хатан эрдэм чадал, авьяас билиг, Арлангуа хатан ёс журмыг сахигч, элбэрэл тахимдуун бэлгэдэлт дүрийг бүтээж явдал үйлээрээ ялгаатай буй нь монголчуудын эмэгтэй хүмүүнийг үзэх үзэл хийгээд эрхэмлэх зан чанарын чухлыг давхар агуулсан нь сонирхолтой юм.

### Summary

A valuable historical source, the Geser Epic is considered the longest literary work in the world. The beauty, wisdom, intelligence and good manners of the beautiful princesses and queens are described as the light of the sun and the moon and their warlocks and feats of bravery have been depicted by the symbolic metaphor identification.

It is interesting that the importance of the Mongolians views and values on women have been revealed by the different figures such as Rogmo Goa by her attractiveness, Aju Mergen by her wisdom and skilled talent and Arulga Goa by her strict morality and mindfulness.

### Номзүй

Гэсэр. Сонгомол эхийг боловсруулж удиртгал, тайлбар бичсэн Ц.Дамдинсүрэн. Уб., 1986.

Гэсэрийн бүрэн бичиг. Тэргүүн боть. Цэцэнмөнх эрхлэн найруулав. Бээжин, Үндэсний хэвлэлийн хороо. Дамдинсүрэн Ц. Гэсэрийн туужийн түүхэн үндэс, Уб., 1989.

Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм, тэргүүн боть, Уб., 1957

Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм, дэд боть, Уб., 1967

Дулам С. Монгол бэлгэдэл зүй, I боть, Тооны бэлгэдэл зүй, “Монгол соёлын чуулган”, VIII боть, Уб., 2007, 2011

Дулам С. Монгол бэлгэдэл зүй, II боть, Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй, “Монгол соёлын чуулган”, IX боть, Уб., 2007, 2011

Дулам С. Монгол соёл иргэншлийн утга тайлал, Уб., 2013

Нандинбилиг Г. Монгол баатарлаг туульс дахь сайхны тухай үзэл. Уб., 2004.

Ринченсамбуу Г. Монгол туульсын авхай дагинасын дүрийн гоо сайхан, Төв Азийн тууль, Олон улсын симпозиум-их наадмын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл, Уб., 1998.

Чингис хааны алтан товч нэртийн цэдиг, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн С.Дашдэжид, Уб., 2015.

МАДУ - Монгол ардын домог үлгэр, эмхэтгэж, удиртгал бичсэн , академич Д.Цэрэнсодном, Уб., 2010.

Т.Баясгалан, Жангарын туулийн хэв шинжийн харьцуулсан судалгаа, Уб., 2010,